



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2025/012/НА-СТА-ТТЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаанбаатар хот
2025 он

Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогч Я.Самбууням
Утас: 261663 Цахим хаяг: sambuunyamy@audit.gov.mn
Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261663 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn
Аудитын менежер: Б.Долгорсүрэн
Утас: 261885 Цахим хаяг: dolgorsuren@audit.gov.mn
Ахлах аудитор: С.Отгонхорлоо
Утас: 261740 Цахим хаяг: otgonkhorloos@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.25 № 01/1214
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны 12 дугаар сарын 31-ний 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг бүх материаллаг талаар нь Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгууль зохион байгуулахтай холбогдуулан улсын төсвөөс 3,663.9 сая төгрөг, орон нутгийн төсвөөс 1,460.0 сая төгрөгийн санхүүжилт батлагдсан бөгөөд сонгуулийн хамгаалалтад зарцуулж 40 нэгжээс 11.8 мянган албан хаагч үүрэг гүйцэтгэсэн байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгааснаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Засгийн газрын 2024 оны 128 дугаар тогтоолоор төрийн албаны зарим албан тушаалын цалингийн доод хэмжээг шинэчлэн тогтоосныг үндэслэн алба хаагчдын цалинг нэмэгдүүлснээс шалтгаалан цалингийн зардал өмнөх оноос 10 хувиар өссөн байна.

“Хэлтэс байгуулах, орон тоо шилжүүлэх, харьяалал, нэршил, цол, цалингийн зэрэглэл өөрчлөлт оруулах тухай” Цагдаагийн ерөнхий газрын даргын 2024 оны А/481 дүгээр тушаалаар Хүч спорт хороог татан буулгаж, Сургалтын нэгдсэн төвтэй нэгтгэсэн байна.

Бусад асуудал

Засгийн газрын 2018 оны 09 дүгээр тогтоолоор Монгол тамга ТӨҮГ-ыг татан буулгах ажлыг Хууль зүй дотоод хэргийн яам, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газартай хамтран хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж, үр дүнг Засгийн газарт танилцуулахыг даалгасан боловч 1.6 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлийг улсын орлогод төвлөрүүлээгүйгээс шийдвэрлэгдээгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ
АУДИТОРЫН ОРЛОГЧ  Я.САМБУУНЯМ



2.Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	127,710,002.2	138,788,232.3
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	15,587,586.6	15,912,362.1
32	БОГИНО ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
33	АВЛАГА	1,793,832.1	1,251,284.3
34	УРЬДЧИЛГАА	42,801,515.9	21,527,802.1
35	БАРАА МАТЕРИАЛ	60,944,545.6	84,917,700.1
36	НӨӨЦИЙН БАРАА	-	-
360	БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ	6,582,522.0	15,179,083.7
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	249,203,135.1	304,019,209.0
37	УРТ ХУГАЦААТ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ	-	-
37100	Урт хугацаат хадгаламж	-	-
37200	Үнэт цаас	-	-
37300	Урт хугацаат зээл	-	-
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	249,203,135.1	304,019,209.0
39100	Газар	-	-
39200	Биет хөрөнгө	227,692,795.5	279,161,924.2
39300	Биет бус хөрөнгө	21,510,339.6	24,857,284.7
39400	Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	376,913,137.4	442,807,441.3
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	13,071,679.2	12,769,736.2
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	13,071,679.2	12,769,736.2
41100	Богино хугацаат үнэт цаас	-	-
41200	Богино хугацаат зээлийн өглөг	-	-
41300	Өглөг	497,022.6	1,902,763.4
41400	Урьдчилж орсон орлого	12,574,656.6	10,866,972.8
42	УРТ ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	-
42100	Урт хугацаат үнэт цаас	-	-
42200	Урт хугацаат зээл	-	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	363,841,458.2	430,037,705.0
51	Засгийн газрын хувь оролцоо	363,841,458.2	430,037,705.0
51100	Засгийн газрын оруулсан капитал	86,512,622.1	88,118,325.2
51200	Хуримтлагдсан үр дүн	222,114,924.3	287,395,989.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	55,213,911.8	54,523,389.9
51400	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-
51500	Бодлогын өөрчлөлт алдааны залруулга	-	-
51600	Нөөцийн сан	-	-
52	Хяналтын бус хувь оролцоо	-	-
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	376,913,137.4	442,807,441.3

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	458,948,427.1	623,172,201.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	40,169,789.8	65,720,511.4
120	Нийтлэг татварын бус орлого	38,988,781.6	64,931,370.5
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	1,181,008.2	789,140.9
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
124	Зээлийн орлого	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,778,637.3	557,451,689.8
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	417,588,383.8	539,639,771.5
21	УРСГАЛ ЗАРДАЛ	417,588,383.8	539,639,771.5
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	374,304,456.9	484,450,876.6
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	275,905,374.1	357,338,228.7
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,497,126.5	8,429,607.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,094,658.1	7,750,660.3
2104	Хангамж, бараа материалын зардал	14,159,556.0	18,133,739.9
2105	Нормативт зардал	13,661,056.2	22,272,856.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,097,762.2	4,304,383.6
2107	Томилолт, зочны зардал	690,054.6	1,756,969.1
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,523,719.5	26,558,969.4
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	30,675,149.6	37,905,461.6
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,283,926.9	55,188,894.8
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	-
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	41,360,043.3	83,532,429.7
IV	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН	89,443.7	1,026.0
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	1,855,232.1	2,102,761.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	39,594,254.9	81,430,694.1

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/мянган төгрөгөөр/

Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Цөөнхийн хувь оролцоо	Нийт цэвэр хөрөнгө/өмч
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	322,174,861.4	-	322,174,861.4
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	348,515.3	-	348,515.3
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	322,523,376.7	-	322,523,376.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(281,106.1)	-	(281,106.1)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	2,004,932.7	-	2,004,932.7
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	39,594,254.9	-	39,594,254.9
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	363,841,458.2	-	363,841,458.2
2024 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	363,841,458.2	-	363,841,458.2
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	(16,149,628.5)	-	(16,149,628.5)
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	347,691,829.7	-	347,691,829.7
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	(690,521.9)	-	(690,521.9)
Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	1,605,703.2	-	1,605,703.2
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-
Өмчид гарсан өөрчилөлт	-	-	-
Зарласан ногдол ашиг	-	-	-
Тайлант үеийн үр дүн	81,430,694.1	-	81,430,694.1
2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	430,037,705.0	-	430,037,705.0

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код:	Тайлангийн үзүүлэлт	/мянган төгрөгөөр/	
		2023 оны 12-р сарын 31	2024 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	440,069,303.2	581,834,900.2
11	ТАТВАРЫН ОРЛОГО	-	-
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	21,387,115.4	23,887,147.8
120	Нийтлэг татварын бус орлого	21,387,115.4	23,887,147.8
121	Хөрөнгийн орлого	-	-
122	Тусламжийн орлого	-	-
123	Улсын төсөв орон нутгийн төсөв хоорондын шилжүүлэг	-	-
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	418,682,187.8	557,947,752.4
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	407,528,952.6	545,874,750.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	407,528,952.6	545,874,750.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	363,776,056.2	488,889,951.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	278,139,091.0	358,659,580.3
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	6,670,846.1	8,576,603.1
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,160,132.8	7,912,810.7
2104	Хангамж, бараа материалын зардал	11,222,450.9	14,337,947.2
2105	Нормативт зардал	12,287,538.3	34,246,134.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	10,450,006.7	9,020,490.5
2107	Томилолт, зочны зардал	764,551.6	1,806,844.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,957,349.3	48,350,264.5
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	4,124,089.4	5,979,276.8
211	ХҮҮ	-	-
212	ТАТААС	-	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	43,752,896.4	56,984,798.1
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	32,540,350.6	35,960,150.2
IV	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (IV)	-	-
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	30,476,317.4	35,239,247.9
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	30,476,317.4	35,239,247.9
2200	Дотоод эх үүсвэрээр	30,476,317.4	35,239,247.9
2260	Гадаад эх үүсвэрээр	-	-
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(30,476,317.4)	(35,239,247.9)
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	172,894.1	(396,126.8)
14	Бусад эх үүсвэр	172,894.1	-
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	-	-
24	ГАДААД ЗЭЭЛИЙН ҮНДСЭН ТӨЛБӨР	-	-
25	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДАЛ	-	396,126.8
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	2,236,927.4	324,775.5
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,350,659.3	15,587,586.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	15,587,586.6	15,912,362.1

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	533,964,189,200.00	532,393,739,985.93	1,570,449,214.07	99.7
УРСГАЛ ЗАРДАЛ	521,662,330,200.00	520,391,081,823.93	1,271,248,376.07	99.8
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	473,726,732,200.00	472,656,968,384.90	1,069,763,815.10	99.8
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	347,947,834,100.00	347,096,209,895.68	851,624,204.32	99.8
Үндсэн цалин	179,018,734,000.00	182,131,680,831.03	(3,112,946,831.03)	101.7
Нэмэгдэл	128,383,733,500.00	125,989,805,696.32	2,393,927,803.68	98.1
Унаа хоолны хөнгөлөлт	3,901,655,500.00	4,438,289,106.99	(536,633,606.99)	113.8
Урамшуулал	22,602,977,800.00	20,923,237,034.48	1,679,740,765.52	92.6
Гэрээт ажлын хөлс	14,040,733,300.00	13,613,197,226.86	427,536,073.14	97.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	8,108,310,000.00	8,036,709,170.29	71,600,829.71	99.1
Тэтгэврийн даатгал	-	9,643,620.81	(9,643,620.81)	
Тэтгэмжийн даатгал	-	1,134,543.27	(1,134,543.27)	
ҮОМШӨ-ний даатгал	-	960,428.27	(960,428.27)	
Ажилгүйдлийн даатгал	-	430,996.86	(430,996.86)	
Эрүүл мэндийн даатгал	8,108,310,000.00	8,024,539,581.08	83,770,418.92	99.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	7,845,481,700.00	7,776,395,860.75	69,085,839.25	99.1
Гэрэл, цахилгаан	2,674,807,200.00	2,685,572,881.85	(10,765,681.85)	100.4
Түлш, халаалт	4,374,414,200.00	4,290,906,937.53	83,507,262.47	98.1
Цэвэр, бохир ус	711,855,300.00	715,511,041.37	(3,655,741.37)	100.5
Байрны түрээс	84,405,000.00	84,405,000.00	-	100.0
Хангамж, бараа материалын зардал	12,943,384,400.00	12,935,275,522.33	8,108,877.67	99.9
Бичиг хэрэг	1,488,981,300.00	1,488,005,305.67	975,994.33	99.9
Тээвэр, шатахуун	9,375,948,800.00	9,352,041,915.80	23,906,884.20	99.7
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,344,015,000.00	1,344,532,220.86	(517,220.86)	100.0
Ном, хэвлэл	104,300,000.00	104,300,000.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,159,200.00	40,057,000.00	102,200.00	99.7
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	589,980,100.00	606,339,080.00	(16,358,980.00)	102.8
Нормативт зардал	33,153,645,100.00	33,147,800,894.03	5,844,205.97	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	50,139,900.00	50,017,802.70	122,097.30	99.8
Хоол, хүнс	4,972,314,100.00	4,955,789,937.10	16,524,162.90	99.7
Нормын хувцас, зөөлөн эдлэл	28,131,191,100.00	28,141,993,154.23	(10,802,054.23)	100.0
Эд хогшил, урсгал засварын зардал	7,441,026,700.00	7,435,645,390.00	5,381,310.00	99.9
Багаж, техник, хэрэгсэл	3,391,676,500.00	3,384,886,537.67	6,789,962.33	99.8
Тавилга	15,117,200.00	20,856,300.00	(5,739,100.00)	138.0
Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	140,887,500.00	137,146,583.33	3,740,916.67	97.3
Урсгал засвар	3,893,345,500.00	3,892,755,969.00	589,531.00	100.0
Томилолт, зочны зардал	1,333,628,000.00	1,326,977,031.00	6,650,969.00	99.5
Гадаад албан томилолт	255,603,300.00	255,603,299.00	1.00	100.0
Дотоод албан томилолт	1,052,554,300.00	1,045,903,320.00	6,650,980.00	99.4
Зочин төлөөлөгч хүлээн авах	25,470,400.00	25,470,412.00	(12.00)	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	52,333,744,200.00	52,283,866,556.64	49,877,643.36	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	49,210,636,600.00	49,175,472,224.32	35,164,375.68	99.9
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,500.00	806,400.00	100.00	100.0
Даатгалын үйлчилгээ	261,731,900.00	261,731,801.00	99.00	100.0
Тээврийн хэрэгслийн татвар	101,311,700.00	93,656,370.22	7,655,329.78	92.4
Тээврийн хэрэгслийн оношлогоо	28,090,700.00	26,109,023.00	1,981,677.00	92.9
Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,093,555,000.00	1,091,209,214.00	2,345,786.00	99.8

Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Газрын төлбөр	116,011,100.00	113,280,824.10	2,730,275.90	97.6
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-	-	
Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,521,600,700.00	1,521,600,700.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,619,678,000.00	2,618,088,064.18	1,589,935.82	99.9
Бараа үйлчилгээний бусад зардал	1,031,015,800.00	1,030,329,245.00	686,555.00	99.9
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,588,662,200.00	1,587,758,819.18	903,380.82	99.9
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,935,598,000.00	47,734,113,439.03	201,484,560.97	99.6
Засгийн газрын урсгал шилжүүлэг	123,527,100.00	123,527,099.00	1.00	100.0
Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-	-	
Засгийн газрын гадаад шилжүүлэг	123,527,100.00	123,527,099.00	1.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	47,812,070,900.00	47,610,586,340.03	201,484,559.97	99.6
Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-	-	
Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	-	-	
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	272,311,900.00	260,679,954.00	11,631,946.00	95.7
Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,907,054,300.00	1,907,054,300.00	-	100.0
Ээлжийн амралтаар нутаг явах унааны хөнгөлөлт	-	-	-	
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	33,210,860,400.00	33,124,578,828.83	86,281,571.17	99.7
Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	5,611,214,300.00	5,577,502,069.80	33,712,230.20	99.4
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	6,810,630,000.00	6,740,771,187.40	69,858,812.60	99.0
ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	12,301,859,000.00	12,002,658,162.00	299,200,838.00	97.6
Барилга байгууламж	11,361,859,000.00	11,063,658,162.00	298,200,838.00	97.4
Их засвар	-	-	-	
Тоног төхөөрөмж	940,000,000.00	939,000,000.00	1,000,000.00	99.9
Бусад хөрөнгө	-	-	-	
Стратегийн нөөц хөрөнгө	-	-	-	
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	533,964,189,200.00	532,765,915,917.95	1,198,273,282.05	99.8
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	517,587,949,000.00	516,302,674,666.02	1,285,274,333.98	99.8
Улсын төсвөөс санхүүжих	517,587,949,000.00	516,302,674,666.02	1,285,274,333.98	99.8
НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	252,495,000.00	263,173,000.00	(10,678,000.00)	104.2
Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	252,495,000.00	263,173,000.00	(10,678,000.00)	104.2
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	16,123,745,200.00	16,200,068,251.93	(76,323,051.93)	100.5
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	16,123,745,200.00	16,200,068,251.93	(76,323,051.93)	100.5
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	-	-	-	
Урьд оны үлдэгдлээс санхүүжих	-	-	-	
Гадаадын эх үүсвэрээс санхүүжих	-	-	-	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	350,000.00	(350,000.00)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	350,000.00	(350,000.00)	
БАЙГУУЛЛАГЫН ТОО	57	57	-	100.0
Төсвийн байгууллага	57	57	-	100.0
АЖИЛЛАГСАДЫН ТОО	12290	11282	1008	91.8
Удирдах ажилтан	179	140	39	78.2
Гүйцэтгэх ажилтан	10844	10013	831	92.3
Үйлчлэх ажилтан	503	425	78	84.5
Гэрээт ажилтан	764	704	60	92.1

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	43,650,196,126.46
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	30,352,483,744.46
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	26,528,373,100.16
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	-	11,545,132,268.01
210101	Үндсэн цалин	-	7,056,709,229.53
210102	Нэмэгдэл	-	422,223,556.24
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	3,429,112.00
210104	Урамшуулал	-	2,031,875,880.90
210105	Гэрээт ажлын хөлс	-	2,030,894,489.34
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	-	539,658,150.37
210201	Тэтгэврийн даатгал	-	70,993,595.45
210202	Тэтгэмжийн даатгал	-	993,266.92
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	614,438.54
210204	Ажилгүйдлийн даатгал	-	269,175.36
210205	Эрүүл мэндийн даатгал	-	466,787,674.10
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	-	130,294,836.86
210301	Гэрэл, цахилгаан	-	45,582,455.86
210302	Түлш, халаалт	-	83,369,221.00
210303	Цэвэр, бохир ус	-	1,343,160.00
210304	Байрны түрээс	-	-
2104	Хангамж, бараа материалын зардал	-	2,352,020,907.15
210401	Бичиг хэрэг	-	213,716,610.00
210402	Тээвэр, шатахуун	-	947,818,204.95
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	945,509,535.20
210404	Ном, хэвлэл	-	31,850,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	-	-
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	213,126,557.00
2105	Нормативт зардал	-	3,090,524,919.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	-	38,239,285.00
210502	Хоол, хүнс	-	2,754,921,408.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	297,364,226.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	3,905,844,035.19
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	3,024,102,015.00
210602	Тавилга	-	82,125,504.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	-	25,857,500.00
210604	Урсгал засвар	-	773,759,016.19
2107	Томилолт, зочны зардал	-	607,427,816.00
210701	Гадаад албан томилолт	-	257,168,676.00
210702	Дотоод албан томилолт	-	315,636,240.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	-	34,622,900.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	2,155,409,525.58
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	2,058,369,525.58
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	-	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	152,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	-	-
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	-	-
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	-	96,888,000.00
210807	Газрын төлбөр	-	-
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	-	-

Цагдаагийн ерөнхий газрын 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	-	-
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	-	2,202,060,642.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	-	1,981,158,542.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	220,902,100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	3,824,110,644.30
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	-	-
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	-	-
213102	Засгийн газрын гадаад шилжүүлэг	-	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	-	1,728,069,546.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	-	-
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	-	-
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	-	45,692,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,682,377,546.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	2,096,041,098.30
213305	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	-	2,096,041,098.30
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	13,297,712,382.00
2200	Дотоод эх үүсвэрээр	-	13,297,712,382.00
220001	Барилга байгууламж	-	5,386,930,682.00
221001	Их засвар	-	-
222001	Тоног төхөөрөмж	-	7,890,881,700.00
223001	Бусад хөрөнгө	-	19,900,000.00
224001	Стратегийн нөөц хөрөнгө	-	-
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	43,650,196,126.46
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	43,650,196,126.46
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	-	213,998,985.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө, түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	22,323,388,252.64
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	3,307,342,532.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	-	17,805,466,356.82

3. Аудитын илрүүлэлт

Аудитаар Санхүүгийн тайлантай холбоотой нийт 11,075.3 сая төгрөгийн 101 алдаа¹ илэрснийг аудитын явцад залруулж, төсвийн төвлөрүүлэн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хийсэн аудитаар нийт 3,199.2 сая төгрөгийн 164 зөрчил² илэрснээс, 0.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 1,093.8 сая төгрөгийн 47 албан шаардлага хүргүүлж, 2,104.5 сая төгрөгийн 114 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн.

Харьяа байгууллагуудын санхүүгийн тайлангийн аудитаар нийт 2,927.7 сая төгрөгийн 155 зөрчил илэрснээс, 0.7 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоож, 935.8 сая төгрөгийн 45 албан шаардлага хүргүүлж, 1,991.1 сая төгрөгийн 107 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд харьяа 59 анги, байгууллагыг нэгтгэснээс холбогдох хуулийн дагуу 1 тайлан гүйцэтгэх ажиллагааны аудит хамрагдаж, 1 тайлан аудитад хамрагдаагүй, ХО данс, 24 байгууллагын санхүүгийн тайланд аудитын үе шатны ажлыг хэсэгчлэн гүйцэтгэж, 32 байгууллагад “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн байна.

Төсвийн төвлөрүүлэн захирагч:

Төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2024 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн аудитаар нийт 271.4 сая төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 0.03 сая төгрөгийн алдааг залруулж, цаашид давтан гаргахгүй байх, таслан зогсоох 158.0 сая төгрөгийн 2 албан шаардлага хүргүүлж, 113.4 сая төгрөгийг зөрчлийг арилгах 7 зөвлөмж өглөө.

5.1 Албан шаардлага

Илрүүлэлт 1. Цагдаагийн ерөнхий газрын харьяа байгууллагуудын 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар нийт 2,927.8 сая төгрөгийн 155 зөрчил илрүүлж, нөхөн төлүүлэхээр 0.7 сая төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 935.8 сая төгрөгийн зөрчлийг таслан зогсоох, давтан гаргахгүй байх 45 албан шаардлага, 1,991.1 сая төгрөгийн 107 зөвлөмж, хариуцлага тооцох 1 албан шаардлага хүргүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.49-т “дотоод аудит гэж төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн төсвийн дотоод хяналтын үйл ажиллагааг”, 5 дугаар зүйлийн 5.1.3-т “санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх”, 5.1.5-д “хариуцлагатай байх”, 6 дугаар зүйлийн 6.1-д “Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй”, 6.6-д “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх”, 15 дугаар зүйлийн 15.4-т “Төсвийн төвлөрүүлэн захирагч нь түүнд харьяалагдах төсвийн талаар дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ”, 15.4.1-д “төсвийн ерөнхийлөн захирагчийн энэ хуулийн 14.2.2, 14.2.3, 14.2.5, 14.2.8-д заасан болон төсвийн шууд захирагчийн энэ хуулийн 16.5-д заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэх” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Цагдаагийн ерөнхий газрын дотоод хяналт, сахилга хариуцлагыг сайжруулж, илэрсэн алдаа, зөрчлийг арилгаж 30.0 хувиар бууруулах арга хэмжээг авч, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлэв.

Илрүүлэлт 2. Тайлант онд цагдаа, дотоодын цэргийн байгууллагын ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн албан хаагч нарт улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан 157.9 сая төгрөгийн үндсэн цалингийн урамшууллыг олгосон байна.

Энэ нь Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолоор баталсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 2.1-д “Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно”, 2.2-д “Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Ажлын байрны тодорхойлолтод заасан үндсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн албан хаагчдад улирлын үр дүнгийн мөнгөн урамшуулалтай давхардуулан үндсэн цалингийн урамшуулал олгосон зөрчлийг таслан зогсоож, давтан гаргахгүй, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалттай холбоотой асуудал

Илрүүлэлт 1. Тайлант оны улсын төсвийн хөрөнгө оруулалтын баталсан төсвийг хэтрүүлэн зарцуулсан 1, гүйцэтгэл удаашралтай 2 ажил байна. Үүнд:

- Ховд аймгийн Жаргалант сумын Цагдаагийн газрын барилгын санхүүжилтийг 1,753.8 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 3,263.4 сая төгрөгийн санхүүжилт олгож, баталсан төсвийг 1,509.6 сая төгрөгөөр хэтрүүлсэн;
- Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сумын Цагдаагийн газрын барилгын санхүүжилтийг 2,242.5 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэл 1,207.8 сая төгрөг буюу 54.0 хувь;
- Төв аймгийн Зуунмод сумын Цагдаагийн газрын барилгын санхүүжилтийг 2,340.9 сая төгрөгөөр баталж, гүйцэтгэл 1,606.5 сая төгрөг буюу 69.0 хувь.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.4-т “төсвийн хөрөнгийн зарцуулалт, үр дүнд хяналт тавих”, 11 дүгээр зүйлийн 11.1.16-т “төсвийн ерөнхийлөн захирагч, төсвийн байгууллага, бусад этгээдэд улсын төсвөөс санхүүжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг батлагдсан төсвийн дагуу олгох” гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Тайлант оны баталсан төсвийн хүрээнд гүйцэтгэлийг санхүүжүүлж, зарцуулалт, үр дүнд хяналт тавьж ажиллах.

2. Улсын төсвийн хөрөнгө, оруулалтын барьцаатай холбоотой асуудал

Илрүүлэлт 2. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2018-2020 онд барьсан барилгын гэрээний хугацаа дууссан, олон жилийн насжилттай 113.4 сая төгрөгийн барьцаа чөлөөлөх эсэх нь тодорхойгүй, дотоод хяналт сул байна.

